



# ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“УЛС, ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2022 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН”-Д ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН КОД: БНА-2022/16-3-ШТА-ГА**

*Магадлалаар баталгаажуулаагүй зураг төсвөөр худалдан авах ажиллагааг зохион байгуулан төслийг хэрэгжүүлж байгаагаас нэмэлт төсөв шаардагдах, барилга байгууламжийн гүйцэтгэл чанаргүй болох сөрөг үр дагавар гарч байна.*

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт  
мэдээллийг дараах хаягаар авна уу  
Цахим хуудас: [www.tailan.audit.mn](http://www.tailan.audit.mn)

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын **дарга,**  
**тэргүүлэх аудитор Б.Мөнхбат**  
Утас: 70442584 цахим хуудас: [munkhbatb@audit.gov.mn](mailto:munkhbatb@audit.gov.mn)  
**Аудитын менежер А.Цээням**  
Утас: 70442424 цахим хуудас: [tseenyma@audit.gov.mn](mailto:tseenyma@audit.gov.mn)  
**Ахлах аудитор Б.Азбаяр**  
Утас: 99061429 цахим хуудас: [azbayarb@audit.gov.mn](mailto:azbayarb@audit.gov.mn)  
**Аудитор Б.Нарангэрэл**  
Утас: 99009293 цахим хуудас: [narangerelb@audit.gov.mn](mailto:narangerelb@audit.gov.mn)

Баянхонгор хот 2023 он

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хуудас: [www.tailan.audit.mn](http://www.tailan.audit.mn)

Тайланг хянасан

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат

Тайланг бэлтгэсэн:

Аудитын менежер А.Цээням  
Ахлах аудитор Б.Азбаяр  
Аудитор Б.Нарангэрэл

2023 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр

Уг тайланг ҮАГ-ын цахим хуудаснаас үзнэ үү: [www.audit.mn](http://www.audit.mn)

Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70442424 дугаарын утас, 70442584 дугаарын факсаар харилцана уу.

ХАЯГ:

Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газар, Нутгийн удирдлагын ордон,  
Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум 64090,  
Баянхонгор аймаг  
Монгол Улс

**АГУУЛГА**

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл 3

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ.....

*Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:*.....

**БҮЛЭГ А. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНАЛД ҮНДЭСЛЭЭГҮЙ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААР НЭН ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ОРХИГДОЖ БАЙНА.....**

*А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нь монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөртэй нийцүүлэн төлөвлөөгүй байна.....*

*А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна. ....*

**БҮЛЭГ Б. ЗУРАГ ТӨСӨВ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛААГҮЙ АЖИЛД ГЭРЭЭ БАЙГУУЛАН АЖИЛЛАЖ АЖИЛ ЭХЭЛСНИЙ ДАРАА МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛЖ БАЙГАА НЬ ТӨСӨВ НЭМЭГДЭХ, АЖИЛ ЧАНАРГҮЙ, АШИГЛАЛТ МУУТАЙ БОЛОХ ҮНДСЭН ШАЛТГААН БОЛЖ БАЙНА. ....**

*Б.1 Үнэлгээний хороо улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна. ....*

*Б.2. Баянхонгор аймагт 2022 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт дундаж гүйцэтгэл 54 хувьтай байна.....*

*Б.3. Санхүүжилтийг зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайлан ажлын тоо хэмжээ нэг бүрээр тулгаж олгосноор өмнөх жилүүдэд гарч байсан илүү санхүүжилт олгодог зөрчил давтагдаагүй байна.....*

*Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт өмнөх онуудаас сайжирч байгаа боловч өмнөх онуудад хяналт тавиагүй улмаас үүссэн үр дагавар арилахгүй байна. ....*

*Б.5. Төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа гишүүн тус бүрээр саналын хуудсаар нэмэлт үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.....*

**БҮЛЭГ В. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТТАЙ ТҮВШИНД ХЭРЭГЖСЭН БАЙНА.....**

*В.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг дунд болон богино хугацааны бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.....*

*В.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг цаг хугацаанд нь зохион байгуулсны үр дүнд гүйцэтгэлийн биелэлт хангалттай байна. ....*

ДҮГНЭЛТ: 31

ЗӨВЛӨМЖ: 32

ҮАГ-ын Гүйцэтгэл, Нийцлийн аудитын газарт хүргүүлэх санал.....

**Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн**

**Товчилсон үгийн тайлбар**

АНТАГ	Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
ГХБХБГ	Газрын харилцаа, борилга, хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
УИХ	Улсын Их Хурал
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХБТХОХ	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс
ЦТС	Цахилгаан түгээх сүлжээ
ЭЗТХ	Эдийн засаг, төлөвлөлтийн хэлтэс

**Хүснэгтийн жагсаалт**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалт	5
Хүснэгт 2	2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалт /өмчлөл/	6
Хүснэгт 3	Яамдад хүргүүлсэн санал	7
Хүснэгт 4	УТХО-ын жагсаалтад батлагдсан ТАХ	7
Хүснэгт 5	Зураг төсөв шаардлагатай ТАХ	9
Хүснэгт 6	Эрх шилжиж ирсэн барилга байгууламжийн хэрэгжилт	14-15
Хүснэгт 7	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн тоног төхөөрөмжийн судалгаа	17-18
Хүснэгт 8	Хэрэгжилт удааширсан ТАХ-ний судалгаа	19
Хүснэгт 9	ТЕЗ-чийн санхүүжилтийн ангилал	20
Хүснэгт 10	2022 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалт	24-25
Хүснэгт 11	Орон нутгийн хөрөнгө оруулалтын засварын ажлын санхүүжилтийн судалгаа	28
Хүснэгт 12	Хөгжлийн төлөвлөгөөнд баталсан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл	29

**Дүрслэлийн жагсаалт**

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Эрх шилжүүлсэн ТАХ-ний сонгон шалгаруулалт	11

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

### Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2023 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/04 дүгээр тушаалаар баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн хийв.

Аудитын зорилт

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль, хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагаа хуульд нийцсэн эсэх;
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт үр дүнтэй хэрэгжсэн эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллага, төсөл, арга хэмжээг гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгууллагын холбогдох үйл ажиллагааг хамруулан төлөвлөлт, судалгаа, шинжилгээний баримт материал, ажлын тайлан, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, ажлын гүйцэтгэл болон гэрээний хэрэгжилтэд төрийн захиргааны байгууллага, аймгийн Засаг дарга, түүний харьяа байгууллагаас хяналт хийсэн ажлын тайлан, баталгаажуулсан ажлын гүйцэтгэлд үндэслэн гүйцэтгэлийн аудитыг хийв.

Аудитыг УТХО-аар 2022 онд Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 115,375.1 сая төгрөгийн өртөгтэй 23 төсөл, арга хэмжээг шинээр баталсан бөгөөд өмнөх оноос шилжиж ирсэн 37,647.6 сая төгрөгийн өртөгтэй 9 төсөл арга хэмжээ, нийт 115,375.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл арга хэмжээ, ОНТХО-ын хүрээнд аймгийн хөрөнгө оруулалт, ангилалдаагүй зардлаас 2022 оны төсвийн жилд 2,070.3 сая санхүүжүүлэхээр баталсан 29 төсөл арга хэмжээг хамруулав.

Аудитын хязгаарлалт

Аудитад 2022 онд Төсвийн тухай хуульд батлагдаж аймгийн ТЕЗ-чид эрх шилжиж ирсэн болон аймгийн ИТХ-аар баталсан хөрөнгө оруулалтын ТАХ-нээс бусад тайлант он болон эх үүсвэрээр хийгдсэн төсөл, арга хэмжээг хамааруулаагүй болно.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитыг АДБОУБ(INTOSAI)-ын Стандартын хорооноос баталсан АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, гүйцэтгэлийн аудит хийх аргачлалыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийж, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авч, харьцуулалт хийн, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, аудитын арга зүйг ашиглан аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээ, шалгах хуудасны дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав.

Аудитын  
бүрэлдэхүүн,  
хугацаа

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Мөнхбат хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер А.Цээням хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Азбаяр, аудитор Б.Нарангэрэл, Д.Цэдэвцэвээн нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

Аудитын талбарын үе шатны ажлыг 2023 оны 03 дугаар сарын 26-аас эхлэн гүйцэтгэсэн ба аудиторууд талбарын ажлын явцад дэд тайлангийн төслийг бичиж, аудитын тайланг удирдлагын зөвлөлийн хурлаар 04 дүгээр сарын 19-ний өдөр хэлэлцүүлж, тайланг баталгаажуулан ҮАГ, бусад холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэв.

Хүндрэл  
бэрхшээл

Байхгүй

## ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

### *Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:*

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хууль нь 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр батлагдсан бөгөөд уг хуульд 2022 оны 01 дүгээр сарын 31, 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрүүдэд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Баянхонгор аймагт нийт 115,375.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 23 төсөл, арга хэмжээнд 26,190.7 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталсан байна.

Үүнээс Баянхонгор аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжиж ирсэн улсын төсвийн хөрөнгө оруулалтын 77,727.5 сая төгрөгийн өртөгтэй 14 төсөл, арга хэмжээг шинээр баталсан бөгөөд өмнөх оноос шилжиж ирсэн 37,647.6 сая төгрөгийн өртөгтэй 9 төсөл арга хэмжээ байна.

### *Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар:*

Баянхонгор аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/24 дүгээр тогтоолоор 2022 оны төсвийг батлахдаа аймгийн хөрөнгө оруулалт, ангилагдаагүй зардлаас 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх 29 төсөл арга хэмжээнд 2,070.3 сая санхүүжүүлэхээр баталсан байна.

2022 онд гүйцэтгэсэн “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн гүйцэтгэлийн аудитаар 8,141.4 сая төгрөгийн зөрчил илэрснээс 4.5 сая төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, зөрчил арилгах 1455.4 сая төгрөгийн 20 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 6,681.5 сая төгрөгийн 13 зөвлөмж, хүргүүлснийг аудитын асуудлын шинжилгээний дагуу давтан шалгав.

## ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ДҮН

**БҮЛЭГ А. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН САНАЛД ҮНДЭСЛЭЭГҮЙ, ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БАТАЛСНААР НЭН ШААРДЛАГАТАЙ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ОРХИГДОЖ БАЙНА.**

**А.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг нь Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй байна.**

**А.1.1.** Жагсаалтад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь “Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-той нийцэж байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Баянхонгор аймагт 2022 онд 136,466.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 30,357.8 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 32 төсөл, арга хэмжээ (цаашид ТАХ гэх) батлагдсаны 51,188.9 сая төгрөгийн 13 ТАХ нь өмнөх оноос шилжиж ирсэн хөрөнгө оруулалт байна.

*Хүснэгт 1. 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалт*

Төсөл, арга хэмжээ	Эрх шилжээгүй ТАХ			Эрх шилжүүлсэн ТАХ			/сая.төгрөг/ Нийт		
	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо хэмжээ	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Өмнөх оноос шилжсэн ТАХ	4	13,541.3	2,700.0	9	37,647.6	13,229.1	13	51,188.9	15,929.1
Шинээр хэрэгжих ТАХ	5	7,550.0	1,467.1	14	77,727.5	12,961.6	19	85,277.5	14,428.7
<b>Дүн</b>	<b>9</b>	<b>21,091.3</b>	<b>4,167.1</b>	<b>23</b>	<b>115,375.1</b>	<b>26,190.7</b>	<b>32</b>	<b>136,466.4</b>	<b>30,357.8</b>

*Эх сурвалж: 2022 оны Монгол Улсын Төсвийн тухай хууль*

Аудитаар 2022 онд шинээр хэрэгжиж эхэлсэн 85,277.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 14,428.7 сая төгрөгийн санхүүжих дүн бүхий 19 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө “Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэж байна. /Хавсралт №1/

**А.1.2.** Баянхонгор аймагт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 77,727.5 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг дунд хугацааны бодлоготой уялдсан, харин 800.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгаагүй байна.

**А.1.3.** Шинээр батлагдаж 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 14 төсөл, арга хэмжээ нь Алсын хараа-2050, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр,

Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаж байна.

“Алсын хараа 2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын “төлөвлөлт төвтэй хөгжил” зорилтын хүрээнд Баянхонгор аймгийн Галуут, Эрдэнэцогт, Баацагаан сумдад “Сумын төвийн шинэчлэл хөтөлбөр” хэрэгжүүлэхээр төлөвлөж, Галуут, Эрдэнэцогт сумдад дэд бүтэц, инженерийн шугам сүлжээ байгуулах ажил хийгдэж байна.

Мөн Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд малын гаралтай органик бүтээгдэхүүнийг бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх, Монголын брэнд бүтээгдэхүүнийг дэлхийн зах зээлд гаргах, үр өгөөжийг сайжруулах зорилгоор хөдөө аж ахуйн кластер төслийг санаачлан 2021 онд 1,500.0 сая, 2022 онд 4,480.0 сая төгрөгийн санхүүжилт олгож үе шаттайгаар хэрэгжүүлж байна.

Баянхонгор аймгийн хөрсний бохирдол, төвлөрлийг сааруулах зорилгоор аймгийн төвийн баруун урд хэсэгт 320 га талбайд 2126 өрх, 7441 хүн ам суурьшихаар “Шинэ суурьшлын бүс”-ийг шинээр төлөвлөж, өмнөх онуудад 640 хүүхдийн сургууль цэцэрлэгийн цогцолборыг барьж, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдэд газар олгож 9 давхар 1700 айлын орон сууц зэрэг бүтээн байгуулалтыг хийсэн бол 2022 онд 7,032.9 сая төгрөгийн өртөг бүхий инженерийн шугам сүлжээ, 8,000.0 сая төгрөгийн өртөг бүхий 10 км хатуу хучилттай авто зам зэрэг цогц бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж аймаг орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулж байна.

## ***А.2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.***

А.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр 85,277.5 сая төгрөгийн өртөг бүхий 19 төсөл арга хэмжээг тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих боломжтой байдлаар төлөвлөсөн байна.

### ***Хүснэгт 2. 2022 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалт /өмчлөл/***

Өмчлөх эрх бүхий этгээд	Эрх шилжсэн ТАХ		Эрх шилжээгүй ТАХ		Дүн
	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	Барилга байгууламж	Тоног төхөөрөмж	
Баянхонгор аймгийн ТЕЗ	58,032.9	1,250.0	4,800.0		64,082.9
<b>БШУЯ</b>	1,801.0	2,190.0			3,991.0
<b>ЗХЖШ</b>			1,550.0		1,550.0
<b>ЭХЯ</b>	14,003.6				14,003.6
<b>ХЗДХЯ</b>			1,200.0		1,200.0
<b>ЭМЯ</b>		450.0			450.0
<b>Дүн</b>	<b>73,837.5</b>	<b>3,890.0</b>	<b>7,550.0</b>	<b>-</b>	<b>85,277.5</b>

*Эх сурвалж: 2022 оны Монгол Улсын Төсвийн тухай хууль,*

**A.2.2.** Жагсаалтад батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 10 төсөл арга хэмжээ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй байна.

Баянхонгор аймгийн Засаг дарга улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад оруулахаар шинээр хэрэгжүүлэх 34 төсөл арга хэмжээг аргачлалын дагуу шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэн жагсаалтыг албан бичгээр холбогдох яаманд хүргүүлэн ажилласан байна. Тухайлбал:

**Хүснэгт 3. Яамдад хүргүүлсэн санал**

Яамд	Огноо	Албан бичгийн дугаар	Хүргүүлсэн саналын тоо	Жагсаалтад батлагдсан ТАХ-ны тоо
Боловсрол соёл шинжлэх ухааны яам	2021.05.03	1a/302	11	1
Соёлын яам	2021.05.03	1a/310	2	
Эрүүл мэндийн яам	2021.05.03	1a/305	3	
Зам тээвэр, хөгжлийн яам	2021.05.03	1a/306	5	1
Эрчим хүчний яам	2021.05.03	1a/304	2	
Засгийн газрын хэрэг эрхлэх газар	2021.05.03	1a/303	3	1
Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам	2021.05.03	1a/307	2	
Шадар сайд	2021.05.03	1a/309	1	
Байгаль орчин аялал жуулчлалын яам	2021.05.03	1a/308	1	
Барилга хот байгуулалтын яам	2021.07.30	1a/496	4	1
<b>Дүн</b>			<b>34</b>	<b>4</b>

Эх сурвалж: Баянхонго аймгийн Засаг даргын яамдад хүргүүлсэн албан бичиг

Дээрх жагсаалтаар хүргүүлсэн 34 саналаас 4 санал нь Монгол улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн хавсралтад улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан байна.

**Хүснэгт 4. УТХО-ын жагсаалтад батлагдсан ТАХ**

№	Хуулийн дугаар	ТЕЗ	Төсөл, арга хэмжээний нэр	Холбогдох яамдад санал хүргүүлсэн эсэх	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжих төсөл арга хэмжээний жагсаалтад батлагдсан ТАХ
1	XII.1.93	БХБС	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	Тийм	Тийм
2	XIX.3.25	ЭМС	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Баянхонгор/	Тийм	Тийм
3	XIII.1.1.315	БШУС	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 3 дугаар баг, "Дуурсах" 2 дугаар цэцэрлэг/	Тийм	Тийм
4	XV.1.1.52	ЗТХС	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/	Тийм	Тийм

Эх сурвалж: 2022 оны Монгол Улсын Төсвийн тухай хууль, Баянхонгор аймгийн Засаг даргын яамдад хүргүүлсэн албан бичиг

Харин 2022 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх эрх шилжиж ирсэн 19,440.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 5,388.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 8 төсөл, арга хэмжээг аймгийн ТЕЗ-ийн саналд үндэслээгүй байна. Тухайлбал:

### **Аудитын илрүүлэлт**

- Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж /Баянхонгор/
- “Түмэн мод” цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Баянхонгор/
- Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийн тоног төхөөрөмж /Баянхонгор/
- Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/
- Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/
- Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн тоног төхөөрөмж /Баянхонгор/
- Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/
- Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Баянхонгор, Баянлиг, Баацагаан, Гурванбулаг, Хүрээмарал, Баян-өндөр, Шинэжинст, Баянговь, Баянцагаан, Заг сум/

Дээрх нөхцөл байдлаас үзэхэд хууль тогтоох эрх бүхий байгууллага нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүйгээр төсөл, арга хэмжээг баталж байгаа нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад бүрэн нийцэх эсэх, төсвийн хөрөнгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх эерэг үр нөлөөг тооцсон эсэхийг нотлох боломжгүй байна.

Мөн Төсвийн тухай хуулиар 2022 онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 74,377.5 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг 10,061.6 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5<sup>1</sup>-д шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлэхээр заасан байхад хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваасан дүнгээс багаар баталж байгаа нь хугацаандаа хэрэгжих боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна. /Хавсралт №2/

Цаашид Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг ТЭЗ-аас ирүүлсэн саналыг үндэслэн хуульд өргөн барьж байх зөвлөмжийг холбогдох яамдад хүргүүлэх саналыг ҮАГ-т хүргүүлэв.

**А.2.3.** Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийхдээ Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчсөн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд эрх шилжүүлсэн 14 төсөл арга хэмжээнээс зураг төсөв шаардлагатай 8 төсөл, арга хэмжээ нь техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон эсэхийг аудитын явцад шалгалаа.

<sup>1</sup> шинээр эхлэх барилга, байгууламж, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг гурван жилд багтаан санхүүжүүлж, дуусгах

Хүснэгт 5. Зураг төсөв шаардлагатай ТАХ

Дд	Төсөл арга хэмжээний нэр	Зураг төсөв боловсруулсан огноо	Магадлалын ерөнхий дүгнэлтийн огноо	Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалттай нийцсэн эсэх	Тайлбар
1	Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/			Тийм	Түлхүүр гардуулах
2	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	2020.06.10	2021.02.10	Тийм	
3	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	2021.12.21	2022.03.15	Үгүй	
4	"Түмэн мод" цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Баянхонгор/	2021.12.01		Үгүй	Магадлалын дүгнэлт гаргаагүй
5	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/	2022.10.11	2022.11.08	Үгүй	
6	110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор/		2022.02.10	Үгүй	Зураг төсөв олдоогүй
7	Цэцэрлэгийн барилга буулгаж, шинээр барих, 150 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 3 дугаар баг, "Дуурсах" 2 дугаар цэцэрлэг/	2021.09.05	2022.01.26	Үгүй	
8	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум/	2021.10.13	2021.12.09	Үгүй	

Эх сурвалж: 2022 оны УТХО-аар хэрэгжүүлэх ТАХ-ны судалгаа

Харин дээрх 8 төсөл арга хэмжээнээс 3 нь улсын төсөв батлагдсанаас хойш зураг төсөв боловсруулсан, 5 нь улсын төсөв батлагдсанаас хойш магадлалаар баталгаажуулах ажлыг зохион байгуулсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>2</sup> дэх заалтыг зөрчих байдал арилахгүй байгаа тул зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэхийг УАГ-ын гүйцэтгэл, нийцлийн аудитын газарт хүргүүлэв.

Мөн "Түмэн мод" цөлжилттэй тэмцэх ногоон байгууламжийн "Багц 2"-ын барилга байгууламжийн ажилд магадлалаар баталгаажсан төсөв гаргаагүй байна.

Цаашид төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг эрэмбэлэн санал хүргүүлж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**A.2.4.** Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад батлагдсан 4 төсөл арга хэмжээний төлөвлөлтийн үе шатны ажлын баримтаас үзэхэд хөрөнгө оруулалтаар бий болох хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, санхүүжүүлэх эх үүсвэр, төсөвт нөлөөлөх ачаалал зэргийг Сангийн яамны <https://pimis.mn> цахим системд оруулж маягтын дагуу боловсруулсан байна.

**A.2.5.** Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан журмыг баримталсан байна.

Аймгийн 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд улсын төсвийн хөрөнгө

<sup>2</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

оруулалтаар эрх шилжсэн 14 нэр төрлийн 77,727.5 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 05-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний хооронд зохион байгуулж, нийт 14 нэр төрлийн 76,508.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны үр дүнд 1,218.6 сая төгрөгийн хэмнэлтийг бий болгосон байна.

Улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр ашиглалтын норм дуусаагүй ижил төрлийн барилга байгууламж барих төслийн санал гаргаагүй байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6<sup>3</sup> дахь заалттай нийцэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хүрээнд нээлттэй тендер шалгаруулалтын журмаар худалдан авч буй бараа, ажил, үйлчилгээний урилгыг ерөнхий гэрээгээр Зууны мэдээ сонинд нийтлүүлсэн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5<sup>4</sup> дахь заалттай тус тус нийцэж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх 21 төсөл арга хэмжээний гүйцэтгэгч, нийлүүлэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн tender.gov.mn цахим системээр 100% зохион байгуулж тендерийн урилга, үр дүнг цахим системд тухай бүр оруулсан байна.

**БҮЛЭГ Б. ЗУРАГ ТӨСӨВ МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛААГҮЙ АЖИЛД ГЭРЭЭ БАЙГУУЛАН АЖИЛЛАЖ АЖИЛ ЭХЭЛСНИЙ ДАРАА МАГАДЛАЛААР БАТАЛГААЖУУЛЖ БАЙГАА НЬ ТӨСӨВ НЭМЭГДЭХ, АЖИЛ ЧАНАРГҮЙ ХИЙГДЭХ, АШИГЛАЛТ ХЭВИЙН БУС БАЙХ ҮНДСЭН ШАЛТГААН БОЛЖ БАЙНА.**

**Б.1 Үнэлгээний хороо улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.**


**Б.1.1** Зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацааг баримтлаагүй байна.

Баянхонгор аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталсан байна. Төлөвлөгөөнд УТХО-аар 77,727.5 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлэх эрх шилжиж ирснийг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулахаар төлөвлөсөн байна.

<sup>3</sup> улсын болон орон нутгийн төсвийн эх үүсвэрээр барьж ашиглалтад оруулсан барилга байгууламжийн ашиглалтын хугацааны норм дуусахаас өмнө ижил төрлийн барилга байгууламж дахин шинээр барих төслийн санал гаргахгүй байх;

<sup>4</sup> Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулах худалдан авах ажиллагааны сонгон шалгаруулалтыг цахимаар зарлана.

Төлөвлөгөөгөөр дээрхи 14 төсөл арга хэмжээнээс 9 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг 2022 оны 01 дүгээр сард, 4 төсөл, арга хэмжээг 02 дугаар сард, 1 төсөл, арга хэмжээг 3 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн ч 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг төлөвлөсөн хугацаандаа зохион байгуулаагүй, 09-52 хоногоор хэтрүүлсэн нь тендерийн захиалгыг ХБТХОХ-ээс ирүүлсэн тухай бүрд зохион байгуулсантай холбоотой байна.



Иймд цаашид худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажиллах зөвлөмжийг аймгийн ОНӨГ-т хүргүүлэв.

Тендерийг зарласнаас хойш тендерийг нээх, гэрээ байгуулахад хууль журамд заасан хугацааг мөрдөж ажилласан бөгөөд, худалдан авах ажиллагааг боломжит хугацаанд зохион байгуулаагүй хугацаа алдсанаас төсөл, арга хэмжээ хэрэгжих боломжгүй болсон нөхцөл байдал үүсээгүй байна.

**Б.1.2** Тендерийн баримт бичгийг тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн хууль журмын дагуу боловсруулсан байна.

Тайлант онд УТХО-аар шинээр хэрэгжих төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах үнэлгээний хороог тухай бүр аймгийн Засаг даргын захирамжаар байгуулсан бөгөөд үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг хууль, журам, жишиг баримт бичгийн дагуу, захиалагчаас ирүүлсэн техникийн тодорхойлолтыг үндэслэн боловсруулж аймгийн ОНӨГ-ын даргаар батлуулсан байна.

Үнэлгээний хорооны шийдвэр нь гишүүдийн 75-аас багагүй хувийн ирцтэйгээр гаргасан ба хүчин төгөлдөр бус шийдвэр гараагүй байна.

Тендерийн баримт бичгийг тендерийн жишиг баримт бичгийг үндэслэн ерөнхий шаардлагыг тавьж, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хүргүүлсэн техникийн тодорхойлолтын дагуу боловсруулсан байна.

**Б.1.3** Үнэлгээний хороо УТХО-аар хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.

Тендерийг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар нээлттэй мэдээлж, тендерийн үйл ажиллагааг 100

% цахим хэлбэрээр зохион байгуулан, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товлосон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант онд эрх шилжиж ирсэн 77,727.5 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулж, тендерт шалгарсан оролцогч нартай 76,508.9 сая төгрөгөөр төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан нь төсөвт 1,218.6 сая төгрөгийн хэмнэлт гарах нөхцөл бүрдсэн байна.

Харин 6,300.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна. Тухайлбал:

**Багийн засаг дарга нарыг чадавхжуулах төсөл арга хэмжээний хүрээнд 300.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тоног төхөөрөмж – нийлүүлэх “Хаш лотиус” ХХК нь 2020 онд 9.4 сая, 2021 онд 34.8 сая төгрөгийн борлуулалтын орлого тайлагнасан байгаа нь тендерийн өгөгдлийн хүснэгтэд заасан 2020, 2021 оны борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь батлагдсан төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна гэсэн шалгуурыг хангаагүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1<sup>5</sup>, 15 дугаар зүйл “Санхүүгийн чадавхийг үнэлэх”, 15.4<sup>6</sup> дэх заалтыг зөрчсөн;**

**“Түмэн мод” цөлжилттэй тэмцэх ногоон байгууламж /Баянхонгор/-** Тус арга хэмжээний Багц-3 автомашин нийлүүлэх 95.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг захиалагч автомашин нийлүүлэх аж ахуйн нэгж байхгүй гэсэн шалтгаанаар ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор түүний усалгаа арчилгаанд шаардлагатай “инженерийн хийцтэй худаг уст цэг шинээр гаргах” ажил болгон өөрчилж худалдах авах ажиллагааг зохион байгуулсан нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 9.28<sup>7</sup> дахь заалтыг зөрчсөн;

**Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/-** Уг ажлыг гүйцэтгэхээр шалгарсан “Рино-Инженеринг” ХХК нь Тендер шалгаруулалтын

<sup>5</sup> Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлан.

<sup>6</sup> Энэ хуулийн 15.3-т заасан баримт бичгээс тухайн тендер шалгаруулалтад ирүүлэх баримт бичгийг тендерийн баримт бичигт заана.

<sup>7</sup> “Барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зөвлөх үйлчилгээний зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер шалгаруулалт зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно”

зааварчилгаа /цаашид ТШЗ гэх/ 7.2-д заасан сүүлийн 3 жилийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ нь нийт батлагдсан төсвийн 50 хувиас багагүй байх, ТШЗ 16.2.1 Шүүхийн ерөнхий зөвлөлийн тодорхойлолт ирүүлээгүй, ТШЗ 17.6.4-д заасан ижил төстэй ажил гүйцэтгэсэн байх гэсэн шалгууруудыг хангаагүй байхад үнэлгээний хорооны олонхийн шийдвэрээр УТХО буцаан татагдах гээд байна гэсэн шалтгаанаар (үнэлгээний хорооны хурлын тэмдэглэлээс) уг компанийг шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1<sup>8</sup>, 14 дүгээр зүйлийн 14.3.1<sup>9</sup>, 15 дугаар зүйлийн 15.3.2<sup>10</sup>, 15.3.4<sup>11</sup> дахь заалтуудыг зөрчсөн;

Мөн аймгийн Орон нутгийн өмчийн газраас 2022 онд зохион байгуулсан УТХО-ын 10,373.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэрийг зөвшөөрөөгүй оролцогчийн Сангийн яамны эрх бүхий этгээдэд гаргасан гомдол нь гомдол гаргагчийн талд шийдвэрлэгдсэн байгаа нь үнэлгээний хороо нь хууль, журмыг бүрэн мөрдөөгүйгээс хүчин төгөлдөр бус хууль зөрчсөн шийдвэр гаргасан байна. Тухайлбал:

### **Аудитын илрүүлэлт**

*- Цэцэрлэгийн барилга буулгаж шинээр барих, Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ, Боловсролын салбарын тоног төхөөрөмж гэсэн 3 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үнэлгээний хорооны шийдвэрийг зөвшөөрөөгүй оролцогчийн эрх бүхий этгээдэд гаргасан гомдол нь гомдол гаргагчийн талд шийдвэрлэгдсэн байгаа нь үнэлгээний хороо нь хууль, журмыг бүрэн мөрдөөгүйгээс хүчин төгөлдөр бус хууль зөрчсөн шийдвэр гаргасан байна.*

Иймд цаашид үнэлгээний хороо нь хууль, журмыг зөрчсөн шийдвэр гаргадаг байдлыг таслан зогсоож хууль зөрчсөн саналыг дэмжсэн үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**Б.2. Баянхонгор аймагт 2022 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт дундаж гүйцэтгэл 54 хувьтай байна.**

**Б.2.1.** 2022 онд санхүүжүүлэхээр баталсан төсөл арга хэмжээнээс 16 төсөл, арга хэмжээ нь барилга байгууламжийн ажил байна.

<sup>8</sup> Тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадлна.

<sup>9</sup> шүүхийн шийдвэр болон төрийн захиргааны эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг;

<sup>10</sup> "тендерт оролцогчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан, шаардлагатай бол аудитын дүгнэлтийн хамт",

<sup>11</sup> тендерт оролцогчийн сүүлийн 5 хүртэлх жилийн хугацаанд хэрэгжүүлсэн тухайн гэрээтэй ижил төстэй бараа, ажил, үйлчилгээний жилийн борлуулалтын талаарх мэдээлэл

Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн

Хүснэгт№ 6. Эрх шилжиж ирсэн барилга байгууламжийн хэрэгжилт

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ байгуулсан дүн	Нийт олгосон санхүүжилт	Гүйцэтгэлийн хувь	Одоогийн нөхцөл байдал гарсан үр дүн
1	Гэр хорооллын цэвэр бохир усны шугам сүлжээ Баянхонгор, Баянхонгор сум	27,000.0	"Б софт" ХХК	26,919.0	2,400.0	9%	Хонгор 1000 хороололос эмнэлгийн ар, ганданийн урдуурх байршилд зургийн дагуу сувгийн ажил хийгдэж байгаа гүйцэтгэлд тулгуурлаж санхүүжүүлсэн.
2	+	1,801.0	"Шинэ өлгийн зам" ХХК	1,801.0	140.0	%	Гүйцэтгэгчид 104.5 сая , зураг төсвийн үнэд 32,4 сая, 3.0 сая төгрөгийг хяналтын зардалд олгосон. Аймгийн ОНӨГ буулгасан материалыг хүлээж аваагүй.
3	Аймгийн шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээ /Баянхонгор, Баянхонгор сум/	7,032.9	"Гал хонгор" ХХК	7,032.9	480.0		Ингэний сүүний үйлдвэрийн барилгыг халаалттай холбох ажлыг хийж гүйцэтгэсэн.
4	Сумын төвийн шинэчлэл /Баянхонгор, Баацагаан сум/	5,000.0	"Рино-Инженеринг" ХХК	4,995.0	-	0%	Тухайн ажил хийгдэж эхлээгүй
5	Аймгийн шинэ суурьшлын бүсийн хатуу хучилттай авто зам, 10 км /Баянхонгор, Баянхонгор сум	8,000.0	"Түм дэлгэрэх" ХХК	7,995.2	1,800.0	34%	Гүйцэтгэгч 2681.5 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан бөгөөд батлагдсан төсвийн хүрээнд 1800.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон. 8-8.5 км замын далангийн болон хөрс тэгшлэх ажил хийгдсэн.
6	Хөдөө аж ахуйн Кластер төслийн газар тариалан, малын тэжээлийн дэд төсөл /Баянхонгор/	10,000.0	багц1-Татах хүч 3.315.066.3	3,315.1	100.0	3%	Агуулахын барилга, Өвлийн хүлэмжийн барилга, Дулаан авто граж, Тэжээлийн үйлдвэрийн барилга, Ажилчдын байрлах байр нийт 5 байр баригдах бөгөөд агуулахын барилгын суурийн ажил хийгдсэн.
7	110/35/6 кВ-ын Баянхонгор дэд станцын өргөтгөл, шинэчлэл /Баянхонгор	14,003.6	ДМТМ ХХК	13,296.7	2,454.0	28%	Гүйцэтгэгч 3668.3 сая төгрөгийн гүйцэтгэл гаргасан. Батлагдсан төсвийн хүрээнд 2453.6 сая төгрөгийн санхүүжилт олгосон 3100.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж авчирсан. Мэргэжлийн шинжээч шаардлагатай.
8	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/	5,000.0	"Алегротонер" ХХК	4,957.0	3,266.7	96%	2022.09.15-нд гүйцэтгэл гаргахдаа нийт ажлын гүйцэтгэлийг 96 хувиар гаргаж баталгаажуулан санхүүжилтийн эрх нээлгэсэн. 313.2 сая төгрөгийг барьцаа дансанд авч үлдсэн. Ажил бүрэн хийгдээгүй. Мэргэжлийн шинжээч ажилласан.
9	"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Эрдэнэцогт сум/	5,000.0	"Бридж бюлдинг" ХХК	4,926.9	2,855.5	85%	Гэрээг 2023.07.01 хүртэл сунгасан Авто замын ажлын гүйцэтгэл 85 %, ажлын гүйцэтгэлийн чанарт УАГ-аас шинжээч ирж ажилласан.

**Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн**

10	Хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн кластер байгуулах /Баянхонгор/	12,000.0	Сант өндөр,	3,074.9	1,200.0	39%	1000 тн Мах ногооны зорь барих ажлыг хийж гүйцэтгэхээс газар шороо, суурь, хана, хамар хана, дээвэр, карказ, шалны ажил хийгдсэн.
			Базардарь ХХК	3,848.1	1,113.6	29%	Ингэний сүүний үйлдвэр барих ажилд Ингэ саах байр, Ингэ ботго байрлах саравч, ингэний сүүний үйлдвэрийн барилга, ажилчдын байр, автомашин, тоног төхөөрөмж хадалдан аях ба 2023 оны 4-р сарын байдлаар ингэний сүүний үйлдвэрийн барилга баригдсан байна.
11	Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Гурванбулаг сум/	3,105.5	Гурван булаг сод	3,105.5	2,541.2	81%	Барилгын ажлыг нийт 81 гүйцэтгэл гаргасан барилгын дотор хамар хананы ажил бүрэн хийгдээгүй байхад гүйцэтгэлийг 100 хувь гаргасан. Захиалагч барьцаа дансанд 564.8 сая төгрөг авч үлдсэн.
12	Сургуулийн барилгын өргөтгөл, 440 суудал /Баянхонгор, Баянхонгор сум, Номгон ахлах сургууль/	4,511.5	Эх бүрдэн	3,101.4	4,512.0	100%	Номгон ахлах сургуулийн гадна цахилгаан, дулаан, цэвэр бохир ус, дотор холбоо дохиолол, гадна холбоо гадна тохижилтын ажил зураг төсөвт бүрэн тусаагүйгээс 1311.6 сая төгрөгөөр төсөв нэмэгдэж нэмэлт гэрээ байгуулж ажлыг гүйцэтгэсэн.
13	Сургуулийн дотуур байрны барилга, 100 ор /Баянхонгор, Баянхонгор сум, 2, 7, 9 дүгээр баг/	1,300.0	"Жамъян пайтан" ХХК	1,266.8	1,266.8	100%	Дотуур байр ашиглалтад орсон ашиглалт хэвийн
14	Цэцэрлэгийн барилга, 280 ор /Баянхонгор, Баянхонгор сум/	3,339.0	Гал хонгор	3,339.0	3,339.0	100%	гадна инженерийн шугам, сүлжээ, цахилгаан сүлжээний ажлын зардал, гадна тохижилт, хашаа, ногоон байгууламж, явган хүний зам, авто зогсоолын ажил төсөвт суугаагүйгээс 1309.0 сая төгрөгөөр төсөв нэмэгдсэн
15	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Галуут сум/	1,970.0	"Жи жи ай" ХХК	1,970.0	1,970.0	100%	Тус барилгын ажлыг 2021.08.12-нд улсын комиссоор хүлээлгэн өгсөн. Ашиглалтын явцад дулаан алдагдал ихтэй хүйтэн байдаг талаар ашиглагчаас албан бичиг ирүүлсэн
16	Соёлын төвийн барилга, 240 суудал /Баянхонгор, Шинэжинст сум/	1,421.6	Стандарт тоосго	1,390.5	1,390.5	100%	Ажлыг бүрэн хийж гүйцэтгэсэн ба Гадна инженерийн шугам сүлжээний 191.6 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж ажлыг хийж гүйцэтгэсэн.

Эх сурвалж: Санхүүжилтийн гүйцэтгэлийн материалаас

**Аудитын илрүүлэлт:**

Цэцэрлэгийн барилга буулгаж шинээр барих /Баянхонгор, Баянхонгор-ын барилгын ажлыг 1,801.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр "Шинэ өлгийн зам" ХХК гэрээ байгуулсан ба гүйцэтгэлээр буулгах ажлыг 140.0 сая төгрөгөөр санхүүжилтийн гүйцэтгэл гаргаснаас гүйцэтгэгчид 104.5 сая төгрөгийг олгосон ба барилгаас буусан материалыг аймгийн ОНӨГ-т хүлээлгэн өгөөгүй байна. Буулгалтаас цаашид худалдан борлуулах боломжтой эсэхийг нотлох боломжгүй байна.

Иймд орон нутгийн өмчид бүртгэлтэй тухайн хөрөнгийг буулгаж түүнээс гарсан буулгалтаас гарсан хөрөнгийн асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

**"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Галуут сум/-д** хийгдэж буй барилга угсралтын ажлыг 96 хувийн гүйцэтгэл гаргасан ба өмнөх онд илүү гаргасан гүйцэтгэлд ажлыг хийлгэхээр албан шаардлага өгсөн боловч гүйцэтгэлд гаргасан ажлыг хийлгээгүй байна.

Тухайн "Сумын төвийн шинэчлэл"-ийн ажлыг 5,000.0 сая төгрөгөөр төсөвт батлуулсан ба зураг төсвийн магадлалаар баталгаажуулахад нийт төсөвт өртөг **9,759.2** мянган төгрөг болж нэмэгдсэн байна. Тухайн ажлыг гүйцэтгэл бүрэн хангагдаагүй, төсөв нэмэгдсэн шалтгаанд хөндлөнгийн шинжээч ажилласан ба гүйцэтгэл болон зураг төсвийн дагуу хийгдсэн эсэх асуудалд хөндлөнгийн шинжээчийн дүгнэлтийг авч үзэх шаардлагатай.

**"Сумын төвийн шинэчлэл" хөтөлбөр /Баянхонгор, Эрдэнэцогт сум/-д** тухайн ажилд 2023.04.16-ний өдөр ҮАГ-аас хөндлөнгийн шинжээч ирж ажилласан бөгөөд шинжээч нь "авто замын ажил технологийн дагуу хийгдээгүй чанар муу, ул, далангийн ажилд зориулалтын бус хайргаар хийсэн, цэвэрлэх байгууламжийн ажлыг тохируулга, шахалт хийлгүйгээр шууд булсан, халаалтын шугам хийгдээгүй, бохирын систем ажиллагаагүй" гэж урьдчилсан байдлаар дүгнэв.

Иймд Галуут, Эрдэнэцогт сумд хийгдэж буй сумын төвийн шинэчлэлийн ажилд тавих хяналтыг сайжруулж, захиалагчийн хяналтын зардлаар зөвлөх үйлчилгээ авч, төслийг чанартай үр дүнтэй зохион байгуулах ажилд онцгой анхаарч ажиллах зөвлөмжийг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**"Түмэн мод" цөлжилттэй тэмцэх ногоон байгууламжийн** 1,000.0 сая төгрөгийн нийт 5 багцад хуваан худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байгуулсан 1-р багцыг "Чандмана хархираа" ХХК 115.5 сая төгрөгөөр гэрээ байгуулж модны суулгац үр нийлүүлэх, 2-р багцыг Хүрэн жинсний овоо" ХХК 726.5 сая төгрөгөөр Гүний худгийн ажил 50.9 сая, 10 ширхэг өвлийн хүлэмж 37.8 сая, 5\*7 хэмжээтэй зорь 58.5 сая мод худалдаалах барилга 8\*6 хэмжээтэй 359.8 сая, 4000 м хашааны ажил 113.4 сая 7 га усалгааны системийн ажил 23.1 сая төгрөгөөр, 3-р багцыг Чоржбүрд ХХК 3 уст цаг байгуулах гэрээг 94.6 сая, 4-р багцыг "Түйн голын төгөл" ХХК Мод үржүүлгийн 12 төрлийн багаж тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээг 37.2 сая, 5-р багцыг "Хийморь Орд констракшин" ХХК ажил гүйцэтгэхээр 227.0 сая төгрөгөөр тус тус гэрээ байгуулсан байна.

**Аудитын илрүүлэлт:**

Түмэн мод цөлжилттэй тэмцэх ногоон байгууламжийн хүрээнд баригдсан 1 давхар 8м\*6м хэмжээтэй барилгыг 359.8 сая төгрөгөөр барьсан ба 1 м.кв үнэ 7.5 сая төгрөг байхаар гүйцэтгэл гарган баталгаажуулж санхүүжилтийг олгосон байна. Энэ нь Баянхонгор аймагт шинээр баригдсан барилгын м.кв-ийн үнэ ханш 1.8 сая төгрөг байхад даруй 4.2 дахин илүү өндөр үнэтэй байна.

Иймд дээрх ажлыг үнэлгээг мэргэжлийн зураг, төсвийн эрх бүхий хөндлөнгийн шинжээчээр үнэлүүлэн бодит гүйцэтгэлийг тогтоож зөрүүтэй тооцсон санхүүжилтийн гүйцэтгэлийн төсөвт буцаан төвлөрүүлэх албан шаардлага өгөв. /Үнийн дүнг мэргэжлийн байгууллага тогтоосны үндсэн дээр тооцно/

**Б.2.2.**Тайланд онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын ажил хийгдээгүй, эрх шилжиж ирээгүй байна.

**Б.2.3.** Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн тоног төхөөрөмж нь баталсан техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлсэн боловч ашиглагч байгууллага нь эзэмших эрхийг бүрэн шилжүүлж аваагүй байна.

Аймгийн ТЕЗ-чид нийт 3,890.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 2,208.0 сая төгрөгийн санхүүжих дүнтэй 6 төсөл, арга хэмжээний хүрээнд тоног төхөөрөмж худалдан авахаар эрх шилжиж ирсэн байна.

**Хүснэгт 7. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн тоног төхөөрөмжийн судалгаа**

№	Төсөл арга хэмжээний нэр	Төсөвт өртөг	Гүйцэтгэгчийн нэр	Гэрээ байгуулсан дүн	Нийт олгосон санхүүжилт	Гүйцэт - гэлийн хувь	Одоогийн нөхцөл байдал гарсан үр дүн
1	Багийн засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмж /Баянхонгор	300.0	Багц-1 "Бүдүма" ХХК	214.8	111.6	100%	Нэг бүрийг 2790.0 мянган төгрөгөөр 77 ширхэг "Нүүдэлчин" мотоцикл 2022.04.11-нд хүлээлгэн өгсөн.
			Багц-2" Хаш лотус" ХХК	84.3	37.8	100%	34 ширхэг зөөврийн компьютер /2240.0/ 12 ширхэг принтер /660.0/ 2022.05.23нд хүлээн авсан байна.
2	Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийн тоног төхөөрөмж /Баянхонгор/	500.0	Саммит компьютер технологи ХХК	403.7	350.0	100%	2022.09.27-нд 17 нэр төрлийн тоног төхөөрөмж, эд хогшил хүлээн авсан.
3	Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Баянхонгор/	1,540.0	Саммит компьютер технологи ХХК	1,479.0	308.0	100%	10 нэр төрлийн тоног төхөөрөмж байгаа бөгөөд 600 ширхэг зөөврийн зом байна.
4	Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн тоног төхөөрөмж /Баянхонгор	650.0	Санкомаркетинг монголиа ХХК	642.1	642.1	100%	Малчдын хүүхдийн болосрол дэмжих тоног төхөөрөмжийг 2022.06.16-нд хүлээн авсан байна.
5	Орон нутгийн үйлдвэрлэлийг дэмжих тоног төхөөрөмж /Баянхонгор, Баянлиг, Баацагаан, Гурванбулаг, Хүрээмарал, Баян-	450.0	Бат билэг гурван эрдэнэ ХХК	445.3	445.3	100%	16 төрлийн тоног төхөөрөмжийг 2022.06.06-ний өдөр хүлээн авсан.

өндөр, Шинэжинст,  
Баянговь,  
Баянцагаан, Заг  
сум/

6	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах тоног төхөөрөмж /Баянхонгор	450.0	Багц1 Ресенг мэд ХХК	312.0	208.0	100%	Цусны 12 ширхэг дэлгэрэнгүй шинжилгээний анализаторыг 2022.07.25-нд хүлээн авсан байна.
			багц2 "Бүдума" ХХК	137.7	92.0	100%	Нэг бүрийг нь 2810.0 мянган төгрөгөөр 49 ширхэг "Бэрс" мотоцикл 2022.05.22-нд хүлээн авсан.
НИЙТ		3,890.0		3,718.9	2,194.8	100%	

Эх сурвалж: Санхүүжилт олгосон гүйцэтгэлийн баримт бичгээс

Аудитаар тоног төхөөрөмжийг газар дээр нь очиж үзэхэд техникийн тодорхойлолтод нийцэж байсан боловч зарим тоног, төхөөрөмжийг аймгийн БШУГ-аас ашиглагч байгууллагад хүргээгүй зөрчил илэрсэн. Тухайлбал:

#### **Аудитын илрүүлэлт:**

- Боловсролын салбарын тоног төхөөрөмж төсөл, арга хэмжээний хүрээнд нийлүүлсэн тоног төхөөрөмжийг Баянцагаан сумын Ерөнхий боловсролын сургуульд хүлээлгэн өгөөгүй,
- Эмэгтэйчүүдийн манлайллыг дэмжих төслийн тоног төхөөрөмжийг Шинэжинст сум Засаг дарга хүлээн авсан боловч 7.0 сая төгрөгийн үнэ бүхий МАХНУВ дэлгэцийг тээвэрлэхэд овор ихтэй, эвдэрч гэмтэх эрсдэлтэйгээс шалтгаалан сумд хүргээгүй байна.

Дээрх хөрөнгийг хүргэх цэгийг аймгийн ЗДТГ-т гэж гэрээнд тусгасан нь ашиглагчид хүргэх зардал нь нэмэлтээр гарах үр дагавар гарч байна.

Иймд тоног төхөөрөмжийг хүлээн авах албан шаардлагыг Шинэжинст сумын ЗДТГ-т хүргүүлэн, цаашид тоног төхөөрөмжийг худалдан авах гэрээ хийхдээ ашиглагч байгууллагад хүргүүлэх асуудлыг шийдвэрлэж тендер зарлаж байх зөвлөмжийг аймгийн Засаг даргад, ашиглагчид хөрөнгийг хуваарийн дагуу бүрэн хүлээлгэн өгөх албан шаардлагыг аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газарт хүргүүлэв.

Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөрийн тоног төхөөрөмжийг хүлээн авч хуваарилахдаа аймгийн төвийн “Номгон”, “Эрдэнэмандал”, “Эрдэм”, “Соого сейко” “Гэгээн сумади” зэрэг 6 сургуульд олгосон нь хөтөлбөрийн гол утга санаа “Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих” гэсэн үндсэн зорилгод нийцээгүй байна.

Иймд дээрх сургуулиудад олгосон тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу хөдөөгийн сумдад хуваарилах ажлыг зохион байгуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**Б.2.4.** Тайланд онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ТЭЗҮ ангилалд төсөв батлагдаагүй, эрх шилжиж ирээгүй байна.

**Б.2.5.** Баянхонгор аймагт хэрэгжсэн Монгол улсын 2021 оны Төсвийн тухай хуульд санхүүжих дүн бүрэн баталж дууссан боловч одоогийн байдлаар бүрэн хэрэгжээгүй 10,823.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 5 барилга угсралтын ажил өнөөг хүртэл дуусаагүй байна.

**Хүснэгт 8. Хэрэгжилт удааширсан ТАХ-ний судалгаа**

ТАХ-ний нэр	Төсөвт өртөг	Нийт батлагдсан				Нийт олгосон				Барьцаа дансанд байршуулсан
		2019	2020	2021	Нийт	2019	2020	2021	Нийт	
Сургуулийн барилга, 320 суудал /Баянхонгор, Баянцагаан сум/-"Навтгар хайрхан" ХХК	4,383.0	800.0	632.9	2,950.1	4,383.0	800.0	632.9	1,219.4	2,652.3	1,562.1
Дотуур байрын барилга, 150 ор /Баянхонгор, Богд сум/-"Хорол багана констракшн" ХХК	2,100.0		500.0	1,600.0	2,100.0					<b>Эрх шилжиж ирээгүй</b>
Дотуур байрын барилга, 75 ор /Баянхонгор, Баянбулаг сум/ - "Стандарт тоосго" ХХК	1,000.0		300.0	700.0	1,000.0		300.0	247.8	547.8	396.6
Сургуулийн барилга, 160 суудал /Баянхонгор, Заг сум/ "Энх баялаг констракшн" ХХК	1,540.0		500.0	1,040.0	1,540.0		500.0	826.3	1,326.3	192.9
Сумын эрүүл мэндийн төвийн барилга /Баянхонгор, Эрдэнэцогт сум/ - "Рино инженеринг" ХХК	1,800.0		300.0	1,500.0	1,800.0					<b>Эрх шилжиж ирээгүй</b>
<b>ДҮН</b>	<b>10,823.0</b>				<b>10,823.0</b>					

Дээрх ажлуудаас эрх шилжсэн төсөл, арга хэмжээнд гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу 2021 онд хийж дуусгах барилга угсралтын ажлыг бүрэн гүйцэтгүүлж, хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй аж ахуйн нэгжүүдэд гэрээний дагуу хариуцлагын арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн боловч дээрх ажлууд хэрэгжээгүй байгаа тул үүргийн гүйцэтгэлийг хангуулах, үүрэг гүйцэтгээгүй удааширснаас төрд учирсан хохирлыг гүйцэтгэгч нараас нэхэмжлэн хууль хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**Б.3. Санхүүжилтийг зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайлан ажлын тоо хэмжээ нэг бүрээр тулгаж олгосноор өмнөх жилүүдэд гарч байсан илүү санхүүжилт олгодог зөрчил арилсан байна.**

**Б.3.1.** Баянхонгор аймгийн Засаг даргад эрх шилжсэн 24 төсөл, арга хэмжээний нийт 37 багц ажилд 24,039.3 сая төгрөгийн санхүүжилтийг аймгийн Төрийн сангийн дансаар дамжуулан олгосон байна. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид эрх шилжин ирсэн дүнгээр авч үзвэл:

**Хүснэгт № 9. ТЕЗ-чийн санхүүжилтийн ангилал**

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	Төсөл, арга хэмжээний тоо	Багцын тоо	Санхүүжүүлсэн дүн	ТАХ-нд олгосон	Барьцаа дансанд байршуулсан	Чанарын баталгааны барьцаа
1	БШУС	7	7	4,597.1	3,935.3	564.8	97.0
2	БОАЖС	2	6	1,099.1	1,099.1	-	-
3	ЭМС	1	2	300.0	300.0	-	-
4	БХБС	4	4	9,576.7	8,685.0	891.7	-
5	ЗГХЭГ	1	2	149.4	149.4	-	-
6	Соёлын сайд	2	2	290.2	290.2	-	-
7	ХХААХҮС	3	11	3,423.1	3,400.6	22.6	-
8	ЗТХС	1	1	1,800.0	1,800.0	-	-
9	Эрчим хүчний сайд	1	1	2,453.6	2,453.6	-	-
10	ХНХС	1	1	350.0	350.0	-	-
	ДҮН	23	37	24,039.3	22,463.2	1,479.1	97.0

Аудитаар төсөл, арга хэмжээ тус бүрийг газар дээр нь очиж гүйцэтгэл гаргасан санхүүжилтийн баримт, ажил тус бүрээр гаргасан ажлын гүйцэтгэлийн хувьтай тулган шалгахад аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтэс нь ажил тус бүрээр хяналтын хуудас хөтөлж, зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайланг авч ил, далд ажлын актыг баримтжуулан фото зургаар баталгаажуулан санхүүжилтийг хянаж олгож байгаа нь өмнөх онд гарч байсан санхүүжилт илүү олгож байсан зөрчлийг бүрэн арилгаж ажилласан байна. /Төсөл, арга хэмжээ тус бүрээр санхүүжилтийн гүйцэтгэлийг баримтжуулан цахимаар нотлох баримтад авав./

**Б.3.2.** Зураг төсөв магадлалаар баталгаажуулаагүй байхад гэрээ хийж ажлыг эхлүүлснээс шалтгаалан өмнөх онд ашиглалтад орсон зарим төсөл, арга хэмжээний нэмэлт ажлын төсөв нэмж батлагдсанаас шалтгаалан нэмэлт гэрээг шууд байгуулан ажлыг гүйцэтгэж байна.

Монгол улсын 2018, 2019 оны төсвийн тухай хуульд баталсан Цэцэрлэгийн барилга, 280 ор /Баянхонгор, Баянхонгор сум/-ын 2,050.0 сая төгрөгийн төсөвт өртгөөр батлагдаж нээлттэй тендер зарлаж “Гал хонгор” ХХК шалгарч аймгийн Засаг даргатай 2018.06.25-ний өдөр БСШУСЯ/201801144 дугаар бүхий гэрээг 1,980.0 сая төгрөгөөр байгуулсан байна.

Гэвч уг барилгын зураг төсвийн төсөв батлагдах үед магадлалаар баталгаажуулаагүйгээс шалтгаалан ажлыг гадна инженерийн шугам, сүлжээ, цахилгаан сүлжээний ажлын зардал, гадна тохижилт, хашаа, ногоон байгууламж, явган хүний зам, авто зогсоолын нэмэлт зардал тусгаагүй байсан бөгөөд төсвийг 2019.09.04-ний өдөр магадлалаар баталгаажуулж төсөвт өртөг 3,339.0 сая төгрөг болон нэмэгдсэн байна.

Улмаар тухайн нэмэгдсэн төсөв нь Монгол улсын 2021 оны төсвийн тухай хуульд 50.0 сая, Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуульд 1,309.0 сая төгрөг нэмж батлагдсанаар 2021.12.02-ний өдрийн 2021/228 тоот гэрээг 1,359.0 сая төгрөгөөр шууд байгуулжээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 29.4<sup>12</sup> дэх заалтыг зөрчиж төсөвт баталснаар цаашид ТБОНӨХБАҮХАТХ хууль зөрчиж шууд гэрээ байгуулах, төсөв батлагдаагүй ажлыг урьдчилан хийснээр ажлын тоо хэмжээ технологийн горим зэрэгт хяналт бүрэн тавихгүй байх зэрэг үр дагавар үүссэн байж болзошгүй байна.

Иймд магадлалаар баталгаажсан зураг, төсөвт тусгасан ажлыг дээрх ажлын тоо, хэмжээ зэргийг тулгаж хяналт хийх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

Мөн Шинэжинст сумын Соёлын төвийн барилгын ажил анх төсөвт 1,230.0 сая төгрөгөөр батлагдаж “Стандарт тоосго” ХХК гэрээ байгуулан ажилласан бол Гадна инженерийн шугам сүлжээний ажил зураг төсөвт суугаагүйгээс 191.6 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулж ажлыг хийж гүйцэтгэсэн.

***Б.4. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт өмнөх онуудаас сайжирч байгаа боловч өмнөх онуудад хяналт тавиагүй улмаас үүссэн үр дагавар арилахгүй байна.***

**Б.4.1.** Гүйцэтгэгчид санхүүжилтийг олгохдоо захиалагч болон гүйцэтгэгчээр хяналт хийлгэсэн тайланг хавсаргаж байгаа нь өмнөх онуудаас ололттой байна.

Аудитаар хөрөнгө оруулалтаар хийгдэж буй ажлын объектууд дээр хяналт хийж үзэхэд захиалагчийн хяналт хийж үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулан ажилласан байна. Тухайлбал өмнөх жилд илэрч байсан сувгийн ажлыг блокоор өрж байсан зөрчлийг давтан гаргаагүй бөгөөд зарим барилгын сувгийн ажилд шаардлага тавьж сувгийн ажлыг дахин хийлгэсэн байгаагаас үзэхэд хяналтын үр нөлөө гарч байна.

Зарим ажилд илэрч байгаа зөрчлөөс үзэхэд хяналт хэрэгжүүлэх үйл явцыг бүрэн хүртээмжтэй хийж чадахгүй байна. Тухайлбал: Галуут сумын соёлын төвийн барилга хүйтэн, дулаан их алддаг, Баацагаан сумын ЭМТ-ийн гадна талбайн ажил бүрэн хийгдээгүй, Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажил чанар байдлын хувьд хангалтгүй зэрэг зөрчлүүд илэрч байна.

<sup>12</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

Иймд ТЕЗ-ч нь ГХБХБГ-т захиалагчийн хяналт хийсэн ажлын үр дүнг чанар байдалтай нь уялдуулж, дээрх гарсан зөрчлийг арилгуулж ажлын хариуцлагыг сайжруулах арга хэмжээг авч ажиллах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Мөн өмнөх оны аудитаар сүүлийн аймгийн Мэргэжлийн хяналтын газарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сүүлийн 5 жилд ашиглалтад орсон төсөл, арга хэмжээнүүдийн чанар, байдалд шалгалт хийж хариуг ирүүлэх албан бичиг хүргүүлсэн боловч шалгалт хийгээгүй ба энэ нь цаашид ч эрсдэлтэй хэвээр байна. Тухайлбал Жинст сумын сургуулийн барилгын дээвэр салхи шуурганд хуурсан, ажлыг чанаргүй хийсэн асуудал олон нийтийн цахим сүлжээнд тавигдаж олон нийтийн анхаарлыг татаж байна.

Мэргэжлийн хяналтын байгууллага татан буугдаж барилгын хяналтын улсын байцаагч чиг үүрийн дагуу аймгийн ГХБХБ газарт шилжиж очсон байна. Иймд барилгын тохируулын болон баталгааны хугацаанд байгаа сүүлийн 4 жилд ашиглалтад орсон барилга байгууламжид хяналтыг хийж биелэлтийг ирүүлэх албан шаардлагыг аймгийн ГХБХБГ-т хүргүүлэв.

**Б.4.2.** Төсвийн ерөнхийлөн захирагчийн хувьд 2022 онд хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд гүйцэтгэл гаргаж буй тухай бүр нь хянаж ажлыг нотлох баримтын хүрээнд баталгаажуулан хяналтыг хэрэгжүүлж байна.

Гэвч хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбоотой төлөвлөлтийн болон холбогдох баримт материалын хувьд иж бүрэн мэдээлэл авахуйц хэмжээнд хувийн хэргийг бүрдүүлээгүй, зарим баримт материал байхгүй, холбогдох газраас гаргуулсан эсэх нь тодорхойгүй, зарим гүйцэтгэгчийн баримт материалыг яамд хүргүүлснээр өөрдөө мэдээллээр хангадаггүй зэрэг зөрчил байсаар байна.

Иймд хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламжийг хувийн хэргийн бүрдэлд байх материалыг иж бүрэн бүрдүүлж буй эсэхэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй агентлагт тавих хяналтыг сайжруулан мэдээллээр хангах бололцоог орчин үеийн цахим технологи ашиглан бүрдүүлж ажиллах зөвлөмжийг аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын хэлтсийн дарга болон ГХБХБГ-ын дарга нарт хүргүүлэв.

***Б.5. Төсөл, арга хэмжээг хүлээн авахдаа гишүүн тус бүрээр саналын хуудсаар нэмэлт үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулж ажилласан байна.***

Барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээн авах комиссын акт гарсан бүртгэл жагсаалтыг аймгийн ГХБХБГ-аас авч үзэхэд Баянхонгор аймагт эрх шилжсэн Хөдөө аж ахуйн кластер-ын хүрээнд хийж гүйцэтгэсэн Ингэний сүүний үйлдвэрийн барилгыг “Базардарь” ХХК нь 1,287.7 сая төгрөгөөр, Спорт цогцолбор, усан

бассейны барилгын ажлыг “РМБ” ХХК нь 8,730.6 сая төгрөгөөр гүйцэтгэж барилгыг комиссоор хүлээлгэн өгсөн байна.

Комиссын гишүүн тус бүр үүрэг даалгаврыг “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн саналын хуудас”-т бичиж комиссоор хүлээн авсан ба комиссын гишүүдээс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гишүүн тус бүрээр гарган ирүүлж гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

**Б.5.2.** Аймгийн ТЕЗ нь 2022 онд хэрэгжүүлэхээр эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс хүлээн авч ашиглалтад орсон 6 төсөл, арга хэмжээнээс 2 төсөл, арга хэмжээний гэрээний үүргийн биелэлтийг тооцож харин үлдсэн 4 төсөл арга хэмжээний гэрээний үүргийн биелэлтийг тооцоогүй, гэрээг дүгнээгүй байна.

Иймд хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний гэрээг дүгнэх зөвлөмжийн аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**Б.5.3.** Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.02.13-ний өдрийн 13/11 тоот тогтоолоор 2021, 2022 онд ашиглалтад орсон улс, орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоон бүртгэлд тусгасны дотор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 11,908.9 сая төгрөгийн 12 барилга байгууламж, 2,119.2 сая төгрөгийн 65 нэр төрлийн тоног төхөөрөмж, 496.8 сая төгрөгийн 4 нэр төрлийн тээврийн хэрэгслийг хөрөнгөд бүртгэсэн байна.

Аудитаар 2021 онд ашиглалтад орж амжаагүй, санхүүжилтийг үлдэгдлийг барьцаа дансанд байршуулсан байсан Усан бассейн спорт цогцолборын барилгыг 2022.12.05-ний өдрийн 2022/26 дугаартай акт үйлдэн хүлээн авсан байна.

Аудитаар барилгын гүйцэтгэлтэй очиж газар дээр нь танилцахад усан бассейн ажиллахгүй байна. Энэ талаар аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ын мэргэжилтнээс тодруулахад “Усан бассейн ажиллах мэргэжлийн багш дасгалжуулагч, эмч холбогдох мэргэжилтэн одоогоор байхгүй байгаагаас ашиглаж чадахгүй байгаа” гэсэн тайлбар өгөв.

Цаашид хөрөнгө оруулалтын үр нөлөөг гаргаж ашиглалтын байдлыг сайжруулах албан шаардлагыг аймгийн Биеийн тамир спортын газарт хүргүүлэв.

Аудитаар Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах төсөл, арга хэмжээний хүрээнд хүлээн авсан мотоциклийг тээврийн хэрэгслийн гэрчилгээг эзэмшлээр бүртгээгүй зэрэг зөрчлүүд илрэв. Тухайлбал:

**Аудитын илрүүлэлт:**

➤ Багийн Засаг дарга нарыг чадавхжуулах тоног төхөөрөмжийн хүрээнд Баацагаан, Гурванбулаг, Галуут сумд 2.8 сая төгрөгийн үнэтэй тус бүр 2 мотоцикл нийт 16.7 сая төгрөгийн мотоциклийн тээврийн хэрэгслийн гэрчилгээг эзэмшилд бүртгээгүй.

Дээрх зөрчил нь Авто тээврийн тухай хуулийн 17.1-д дэх заалт-ыг заалтыг зөрчсөн тул хөрөнгийг эзэмшилд бүртгэх албан шаардлагыг холбогдох сумдын Засаг дарга нарт хүргүүлэв.

**БҮЛЭГ В. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ГЭРЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТТАЙ ТҮВШИНД ХЭРЭГЖСЭН БАЙНА.**

**В.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр төсөл, арга хэмжээг дунд болон богино хугацааны бодлоготой уялдуулан төлөвлөсөн байна.**

**В.1.1.** Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1,677.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээ нь Алсын хараа-2050, Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Баянхонгор аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Баянхонгор аймгийг 2016-2025 онд хөгжүүлэх хөгжлийн бодлого, Баянхонгор аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл зэрэг урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаж байна.

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн 6/24 дүгээр тогтоолоор Баянхонгор аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд нийт 48 арга хэмжээнд 1,888.8 сая төгрөг, орон нутгийн хөрөнгө оруулалтаар их засварын ажилд 9 арга хэмжээнд 1015.5 сая төгрөгийг баталсан.

Аудитаар 2022 аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний жагсаалтад багтсан хөрөнгө оруулалтын шинж чанартай 24 төсөл, арга хэмжээний 1677.4 сая төгрөгийг түүвэрлэн авч үзлээ.

**Хүснэгт 10. 2022 оны Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалт /сая.төгрөг/**

№	Төсөл арга хэмжээний нэр	Төрөл	Төсөвт өртөг	Гүйцэтгэл
1	Галуут сумын ЭМТ-ийн хуучин халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувиллын төв болгох	Их засвар	100.0	100.0
2	Заг сумын ЭМТ-ийн Халдвартын эмнэлгийг стандартад нийцүүлэн засварлах	Их засвар	47.0	47.0
3	Богд сумын ЕБС-ийн барилгын засвар хийх	Их засвар	75.4	75.4
4	Дөвөнтийн заалны их засвар хийх	Их засвар	263.1	263.1
5	Бууцагаан сумын хуучин сургуулийн дээврийн их засвар	Их засвар	100.0	100.0
6	Баянхонгор сумын 4-р цэцэрлэгийн их засвар	Их засвар	170.0	170.0
7	Баян-Овоо сумын дотуур байрны их засвар	Их засвар	100.0	100.0
8	Жаргалант сумын сургуулийн их засвар	Их засвар	60.0	60.0
9	Баянхонгор сумын төв цэнгэлдэх хүрээлэнд хөнгөн атлетикийн талбай байгуулах	Их засвар	150.0	148.3

**Улс, орон нутгийн төсвийн 2022 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн**

№	Төсөл арга хэмжээний нэр	Төрөл	Төсөвт өртөг	Гүйцэтгэл
10	"Чингис хааны хөрөг" худалдан авах /Музейд/	Тоног төхөөрөмж	18.0	18.0
11	Музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах дохиолол хамгаалалтын системийг шинэчлэх	Тоног төхөөрөмж	20.0	13.0
12	Тэмүжин театрыг үзэгчдийн сандал, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	Тоног төхөөрөмж	20.0	20.0
13	Сумдын санхүүгийн албаны 20 нэгж, аймгийн төрийн сангийн төлбөр тооцоог цахимжуулах, нэгжүүдийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх	Тоног төхөөрөмж	79.0	79.0
14	Баацагаан сумын цаг уурын тоног төхөөрөмжийг шинэчлэх	Тоног төхөөрөмж	20.0	20.0
15	Аймгийн ЗДТГ-ын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл	Их засвар	149.9	147.0
16	Архивын байрыг иж бүрэн камержуулах	Тоног төхөөрөмж	17.0	10.2
17	ШШГГ-ын уулзалтын өрөөг сайжруулах	Их засвар	10.0	10.0
18	Хатансуудал, Цагаанбогдын албаны байруудад засвар хийх ажилд дэмжлэг үзүүлэх	Их засвар	20.0	20.0
19	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ТАСЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	Тоног төхөөрөмж	65.0	65.0
20	Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	Их засвар	18.0	18.0
21	Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	Их засвар	10.0	-
22	Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	Их засвар	20.0	-
23	Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний Киоск машин байршуулах	Тоног төхөөрөмж	80.0	-
24	Сумдын газрын албаны даамлуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх	Тоног төхөөрөмж	65.0	65.0
			<b>1,677.4</b>	<b>1,549.0</b>

*Эх сурвалж: Баянхонгор аймгийн 2022 оны төсөв баталсан тогтоол*

Аудитаар 2022 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 1677.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн “Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-д суурилсан “Аймгийн засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т нийцүүлэн төлөвлөсөн байна. /Хавсралт №3/

**В.1.2.** Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 24 төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжих 1,677.4 сая төгрөгийг тайлант онд бүрэн олгохоор баталсан байгаа нь төсөл арга хэмжээнүүдийг он дамжихгүй бүрэн хэрэгжих боломжоор хангасан байна.

Баянхонгор аймгийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө ашиглагч байгууллагаас ирүүлсэн санал, албан бичгийг үндэслэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2022 оны төсвийн ерөнхийлөн захирагчийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тодотгон батлагдсан төлөвлөгөөнд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 14 нэр төрлийн 2505.9 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар төлөвлөгөөнд тусгагдсан худалдан авах ажиллагааг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс 04 дүгээр сарын 03-ны хооронд төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг 100% цахим хэлбэрээр зохион байгуулж, төрийн худалдан авах ажиллагааны нэгдсэн tender.gov.mn цахим системээр тендерийн урилга, үр дүнг тухай бүр оруулсан.

Худалдан авах ажиллагааны үр дүнд 125.5 сая төгрөгийн хэмнэлт бий болсон, ашиглалтын норм дуусаагүй ижил төрлийн барилга байгууламж барих төслийн санал гаргаагүй, тендерийг Зууны мэдээ сонинд нийтлүүлсэн зэрэг нь Төрийн хэмнэлтийн тухай хуультай нийцэж байна.

***В.2. 9.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг цаг хугацаанд нь зохион байгуулсны үр дүнд гүйцэтгэлийн биелэлтийн ихэнх төсөл, арга хэмжээ нь хангалттай хэрэгжсэн байна.***

**В.2.1.** Тендерийг зарлахдаа тендерийн урилга, холбогдох баримтыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим сайтаар нээлттэй мэдээлж, тендерийн үйл ажиллагааг 100 % цахим хэлбэрээр зохион байгуулан, оролцогч болон үнэлгээний хорооны гишүүдийг байлцуулан тодорхой, товлосон цагт нээж байгаа нь гүйцэтгэгчийг ил, тод, нээлттэй өрсөлдөх боломжоор ханган Сангийн сайдын 2019 оны 255 дугаар тушаалаар батлагдсан “Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээлэх журам”-ын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.

Тайлант онд аймгийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардал болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлэх их засварын ажилд батлагдсан 2505.9 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээнд худалдан авах ажиллагаа зохион байгуулсан бөгөөд нээлттэй тендер шалгаруулалтын аргаар 12, харьцуулалтын аргаар 2 төсөл арга хэмжээг сонгон шалгаруулж, тендерт шалгарсан оролцогч нартай 2,380.4 сая төгрөгөөр төсөл, арга хэмжээг гүйцэтгэх гэрээ байгуулсан нь төсөвт 125.5 сая төгрөгийн хэмнэлт гарах нөхцөл бүрдсэн байна.

Харин аймгийн Засаг даргын 2021 оны А/212, А217 дугаар захирамжаар байгуулсан үнэлгээний хороо нь 323.1 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна. Тухайлбал:

**Богд сумын Ерөнхий боловсролын сургуулийн барилгын засвар хийх-** 350.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий тендерт шалгарсан "Түйн долгио" ХХК нь ТШЗ 16.1-д заасан "Монгол улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн, өр төлбөргүй байх шаардлагатай" гэсэн шалгуурыг хангаагүй буюу 162.2 мянган төгрөгийн татварын өртэй байхад хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ

хуулийн 12 дугаар зүйлийн 12.1<sup>13</sup>, 14 дүгээр зүйлийн 14.1.2<sup>14</sup> дэх заалтуудыг зөрчсөн байна.

**Жаргалант сумын сургуулийн их засвар-** 124.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Тендерт шалгарсан "Ерөөл нэмэх" ХХК нь ТШЗ 17.2-д заасан "2020,2021 онуудын борлуулалтын орлогын дундаж хэмжээ батлагдсан нийт төсөвт өртгийн 60 хувиас багагүй", ТШЗ 17.6 "2020,2021 онуудын аль нэг жилд доод тал нь нэг удаа батлагдсан төсөвт өртгийн 60 хувиас багагүй үнийн дүнтэй ажил гүйцэтгэсэн байвал зохино" гэсэн шалгууруудыг хангаагүй байхад хамгийн сайн үнэлэгдсэн тендерээр шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 12 дугаар зүйлийн 12.1<sup>15</sup>, 14 дүгээр зүйлийн 14.1.2<sup>16</sup> дэх заалтуудыг зөрчсөн байна.

Иймд цаашид үнэлгээний хороо нь хууль, журмыг зөрчсөн шийдвэр гаргадаг байдлыг таслан зогсоож хууль зөрчин саналыг дэмжсэн үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцох албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

**В.2.2.** Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн 1,015.5 сая төгрөг 9 төсөл арга хэмжээнд /их засварт/ зарцуулж ашиглалтад хүлээн авсан нь үр дүнгээ өгч байна.Тухайлбал:

- *Заг сумын ЭМТ-ийн дээврийн засварын ажлыг “Жаргантай хөх тариа” ХХК 47.0 сая төгрөгөөр, Бууцагаан сумын хуучин сургуулийн дээврийн засварын ажлыг “Алегротовер” ХХК 250.3 сая төгрөгөөр хийснээр цаашид барилгын ашиглалт насжилтад эерэг нөлөө үзүүлж байгаа ч уг барилгыг Бууцагаан суманд Шинэ сум төсөл хэрэгжсэнээр 2016 оноос хойш ашиглалтгүй байна.*
- *“Дөвөнт”-ийн заалны засвар хийснээр хуучин хүйтэн, ашиглалт хэвийн жигд бус тохь тух муутай байсныг өөрчлөн ашиглалт сайжран, хүүхэд, залуучуудын биеийн тамираар хичээллэх бололцоо бүрдсэн.*
- *Баянхонгор сумын 4 дүгээр цэцэрлэгийн засварын ажлыг “Жаргантай хөх тариа” ХХК 350.0 сая төгрөгөөр хийснээр бүх ангийн засвар, халаалтын системийг шинэчилснээр дулаан, хийгдэж тохилог орчин бүрдсэн.*

Мөн Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд батлагдсан хөрөнгө оруулалтын ажлаар хийсэн 751.0 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээнээс 641.0 сая төгрөгийн 13 төсөл, арга хэмжээг гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний үр дүнг дараах байдлаар гарч байна.

<sup>13</sup>тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадална.

<sup>14</sup> Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;

<sup>15</sup>тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаж, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тендер шалгаруулалтад оролцохыг сонирхсон этгээдүүдийн ерөнхий, санхүүгийн, техникийн чадавх болон туршлагыг энэ хуулийн 14-16 дугаар зүйлд заасан үзүүлэлтээр хянан үзэж магадална.

<sup>16</sup> Монгол Улсын, эсхүл үүсгэн байгуулагдсан улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө төлөөгүй;

- Баянхонгор сумын төв цэнгэлдэх хүрээлэнд хөнгөн атлетикийн талбай байгуулах ажлыг 150.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн ба талбайг цементэн эко хавтангаар хийснээр тоосжилт багассан байна.
- Архивын тасгийг камержуулснаар аюулгүй байдал хангагдаж байна.

Аудитаар дээр байгууллагуудын ашиглагч нараас ашиглалтын талаарх саналыг албан бичиг хүлээн авахад ашиглалт хэвийн ба гэмтэл доголдолтой асуудал гараагүй байна.

**В.2.3.** Баянхонгор аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтаар их засварын 9 ажлыг 1,015.5 сая төгрөгөөр хийхээр төлөвлөсөн бөгөөд засварын ажлын 1015.5 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон байна.

*Хүснэгт 11. Орон нутгийн хөрөнгө оруулалтын засварын ажлын санхүүжилтийн судалгаа*

№	Төсөл арга хэмжээний нэр	2022 онд санхүүжих	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Галуут сумын ЭМТ-ийн хуучин халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувиллын төв болгох	100.0	100.0	-
2	Заг сумын ЭМТ-ийн Халдвартын эмнэлгийг стандартад нийцүүлэн засварлах	47.0	47.0	-
3	Богд сумын ЕБС-ийн барилгын засвар хийх	75.4	75.4	-
4	Дөвөнтийн заалны их засвар хийх	263.1	263.1	-
5	Баянговь сумын цэцэрлэгт хүрээлэнгийн засвар	100.0	100.0	-
6	Бууцагаан сумын хуучин сургуулийн дээврийн их засвар	100.0	100.0	-
7	Баянхонгор сумын 4-р цэцэрлэгийн их засвар	170.0	170.0	-
8	Баян-Овоо сумын дотуур байрны их засвар	100.0	100.0	-
9	Жаргалант сумын сургуулийн их засвар	60.0	60.0	-
	Дүн	<b>1,015.5</b>	<b>1,015.5</b>	-

Дээрх Галуут сумын ЭМТ-ийн засвараас бусад засварын ажлуудыг комиссоор хүлээлгэн өгсөн ба санхүүжилтийг гүйцэтгэлд тулгуурлан олгосон байна.

**Аудитын илрүүлэлт:**

- Галуут сумын ЭМТ-ийн хуучин халдвартын эмнэлгийн барилгыг засварлаж ахмадын амралт сувиллын төв болгох ажлын санхүүжилт 100.0 сая төгрөгийг бүрэн авсан байхад одоог хүртэл засварлаж дуусгаагүй байна.

Энэ нь Иргэний хуулийн 350.1.1-д заасан заалт, гэрээний хугацаа зэргийг зөрчиж байгаа тул гэрээний гүйцэтгэлийг хангуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлж, алданги тооцох зөвлөмжийг хүргүүлэв.

Аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд туссан дараах 751.0 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээнд 622.3 сая төгрөгийг олгосон байна.

*Хүснэгт№ 12. Хөгжлийн төлөвлөгөөнд баталсан хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл*

№	Төсөл арга хэмжээний нэр	2022 онд санхүүжих	Гүйцэтгэл	Үлдэгдэл
1	Баянхонгор сумын төв цэнгэлдэх хүрээлэнд хөнгөн атлекийн талбай байгуулах	150.0	148.3	1.7
2	"Чингис хааны хөрөг" худалдан авах /Музейд/	18.0	18.0	-
3	Музейн үзмэрийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах дохиолол хамгаалалтын системийг шинэчлэх	20.0	13.0	7.0
4	Тэмүжин театрыг үзэгчдийн сандал, гэрэлтүүлгийн тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах	20.0	20.0	-
5	Сумдын санхүүгийн албаны 20 нэгж, аймгийн төрийн сангийн төлбөр тооцоог цахимжуулах, нэгжүүдийн тоног төхөөрөмжүүдийг шинэчлэх	79.0	79.0	-
6	Баацагаан сумын цаг уурын тоног төхөөрөмжийг шинэчлэх	20.0	20.0	-
7	Аймгийн ЗДТГ-ын хурлын заалны тохижилт, тоног төхөөрөмжийн шинэчлэл	147.9	147.0	0.9
8	Архивын байрыг иж бүрэн камержуулах	17.0	10.2	6.8
9	ШШГГ-ын уулзалтын өрөөг сайжруулах	10.0	10.0	-
10	Хатансуудал, Цагаанбогдын албаны байруудад засвар хийх ажилд дэмжлэг үзүүлэх	20.0	20.0	-
11	Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ТАСЗ-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	65.0	65.0	-
12	Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	18.0	18.0	-
13	Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	10.0	-	10.0
14	Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийх	20.0	-	20.0
15	Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний Киоск машин байршуулах	80.0	-	80.0
16	Сумдын газрын албаны даамлуудын тоног төхөөрөмжийг шинэчлэх	56.1	53.8	2.3
	Дүн	751.0	622.3	128.7

Эх сурвалж: Санхүүжилтийн гүйцэтгэлийн материал

Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн системийн нэмэлт хөгжүүлэлт хийх 30.0 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ, Аймгийн хэмжээнд төрийн үйлчилгээний Киоск машин байршуулах 80.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлээгүй тул санхүүжилтийг олгоогүй байна.

**В.2.4.** Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй их засварын ажлуудад явцын хяналтыг тухай бүр нь тавьсан бөгөөд санхүүжилтийг фото тайлан гүйцэтгэлийн төсөв зэргийг баримт материалд тулгуурлан баталгаажуулж байна.

Харин тоног төхөөрөмжийн болон камержуулалт зэрэг ажлыг ажлын хэсэг хүлээж авах үедээ тоо хэмжээ болон чанар байдалд хяналт хийж авсан байна.

**В.2.5.** Аймгийн ИТХ-ын хуралдааны 2023.02.13-ний өдрийн 13/11 тоот тогтоолоор 2021, 2022 онд ашиглалтад орсон улс, орон нутгийн болон орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эзэмшигчийг тогтоон бүртгэлд тусгасны дотор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн 1,141.6 сая төгрөгийн 6 төрлийн засварын ажлыг сайжруулалтаар, 221.5 сая төгрөгийн 30 нэр төрлийн тоног төхөөрөмжийг хөрөнгөд бүртгэсэн байна.

**Аудитын илрүүлэлт:**

➤ Заг сумын Эрүүл мэндийн төвийн Халдвартын эмнэлгийг стандартад нийцүүлэн засварлах 86.8 сая төгрөгийн засварын ажлыг 2022.10.26-нд комиссоор хүлээн авсан, Дөвөнтийн заалны их засвар хийх 263.1 сая төгрөгийн ажлыг 2022.12.23-ний өдөр хүлээн авсан байхад хөрөнгийг данс бүртгэл тусгах шийдвэр гараагүй хөрөнгийг бүртгээгүй байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.24.2 дахь заалтыг хэрэгжжүүлээгүй байна.

Иймд комисс ажиллаж ашиглалтад хүлээн авсан 349.9 сая төгрөгийн засварын ажлыг хөрөнгийн бүртгэлд тусгуулах шийдвэр гаргуулах албан шаардлагыг аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүргүүлэв.

Аудитаар нийт 3,240.2 сая төгрөгийн зөрчил илрүүлж 2,095.6 сая төгрөгийн зөрчлийг арилгах 11 албан шаардлага өгч, 1,144.7 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргуулахгүй байх 7 зөвлөмжийг холбогдох байгууллага албан тушаалтнуудад хүргүүлэв.

-oOo-

## ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим төсөл арга хэмжээ нь Төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй байна.
2. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, түүнд магадлал хийж баталгаажуулах ажлыг Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтыг зөрчдөг байдал арилахгүй байна.
3. Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа төсвийн ерөнхийлөн захирагчийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан хугацааг баримтлаагүй байна.
4. Үнэлгээний хороо УТХО-аар хэрэгжүүлэх зарим төсөл арга хэмжээний гүйцэтгэгийг сонгон шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийг зөрчсөн байна.
5. Баянхонгор аймагт 2022 онд эрх шилжиж ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нийт дундаж гүйцэтгэл 54 хувьтай байна.
6. Санхүүжилтийг зохиогчийн болон захиалагчийн хяналтын тайлан ажлын тоо хэмжээ нэг бүрээр тулгаж олгосноор өмнөх жилүүдэд гарч байсан илүү санхүүжилт олгодог зөрчил арилсан байна.
7. Төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт өмнөх онуудаас сайжирч байгаа боловч өмнөх онуудад өгсөн шийдвэрийн хэрэгжилт бүрэн хангагдаагүй байна.
8. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх 24 төсөл, арга хэмжээний тухайн онд санхүүжих 1,677.4 сая төгрөгийг тайлант онд бүрэн олгохоор баталсан байгаа нь төсөл арга хэмжээнүүдийг он дамжихгүй бүрэн хэрэгжих боломжоор хангасан байна.
9. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг цаг хугацаанд нь зохион байгуулсны үр дүнд гүйцэтгэлийн биелэлтийн ихэнх төсөл, арга хэмжээ нь хангалттай хэрэгжсэн байна.

-оОо-

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.Үүнд:

### **НЭГ. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА Д.МӨНХСАЙХАН ТАНАА:**

1. Төсөвлөлтийн шаардлага хангасан төсөл арга хэмжээг эрэмбэлэн саналыг хүргүүлж байх.
2. Техник, тоног төхөөрөмж, бараа худалдан авах гэрээг байгуулахдаа ашиглагч байгууллагад хүргүүлэх, нэмэгдэл зардал гаргахгүй нөхцөлийг бүрдүүлж, худалдан авах ажиллагааг зохион байгуулах.
3. Галуут, Эрдэнэцогт сумд хийгдэж буй сумын төвийн шинэчлэлийн ажилд тавих хяналтыг сайжруулж, захиалагчийн хяналтын зардлаар зөвлөх үйлчилгээ авч, төслийг чанартай үр дүнтэй зохион байгуулах ажилд онцгой анхаарч ажиллах.
4. Эрх шилжин ирсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс хүлээн авч ашиглалтад орсон ажлын гэрээний үүргийн биелэлтийг тооцож гэрээнд заасны дагуу алданги тооцох.

### **ХОЁР. БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗДТГ-ЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА Т.ХИШИГБААТАР ТАНАА:**

1. Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга байгууламжийг хувийн хэргийн бүрдэлд байх материалыг иж бүрэн бүрдүүлж буй эсэхэд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж буй агентлагт тавих хяналтыг сайжруулан мэдээллээр хангах бололцоог орчин үеийн цахим технологи ашиглан бүрдүүлж ажиллах.

### **ГУРАВ. АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН ДАРГА Ц.ИДЭРМӨНХ ТАНАА:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хугацааг мөрдөж ажиллах.
2. Магадлалаар баталгаажаагүй төсөл, арга хэмжээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулахгүй байх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 12 дугаар сарын 01-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт холбогдох нотлох баримтын хамт ирүүлнэ үү.

-оОо-

## ҮАГ-ын Гүйцэтгэл, Нийцлийн аудитын газарт хүргүүлэх санал

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг ТЕЗ-аас ирүүлсэн саналыг үндэслэн хуульд өргөн барьж байх зөвлөмжийг холбогдох яамдад хүргүүлэх.
2. Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4<sup>17</sup> дэх заалтыг зөрчих байдал арилахгүй байгаа тул зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлэх.

-оОо-

<sup>17</sup> Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана